



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 15 өдөр

Дугаар A/246

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Авто замын сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Нийтийн 2000м² зогсоол шинээр хийх (Булган сум) 2 дугаар багцын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Арвин ган бумба” ХХК-тай 59,320,995 (тавин есөн сая гурван зуун хорин мянга есөн зуун ерэн тав) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

2.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Арвин ган бумба” ХХК-ийн захирал (Х.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

3.Тус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Булган сумын Засаг дарга (Д.Бямбажаргал)-д даалгасугай.

4.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Авто замын сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (О.Сайнзаяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



04 Аймгийн Засаг даргын 2015 оны
 дүгээр сарын 15-ны/ний өдрийн
 А/246 дугаар захирамжийн хавсралт

Д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадлашгүй ажил	915 454	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	915 454	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	457 727	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	6 600 00	Ү.Бямбасүрэн
5	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 30 хоног	Ү.Бямбасүрэн
6	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.3 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	О.Сайнзаяа
7	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	О.Сайнзаяа Ү.Бямбасүрэн